



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар A/14

Улаанбаатар хот

Г

Г

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.2, 6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" төсөл арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх Олон Улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн бий болох Богд хаан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр, логистикийн нэгдсэн төвийн техник эдийн засгийн үндэслэл, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, байрзүйн зураг (Төв, Сэргэлэн), Инженерийн дэд бүтцийн судалгаа, эх үүсвэрийг тодорхойлох зураг төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Улсын хэмжээнд)" төсөл арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх Эрүүл мэндийн төв (10,15,22 ортой)-ийн барилгын нэг маягийн зураг төсөв /Улсын хэмжээнд/ боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх зураг төсөв боловсруулах ажлын даалгавруудыг үндэслэн нарийвчилсан төлөвлөгөө гарган батлуулж, ажлын хэсгүүдийг удирдлага, арга зүйгээр хангаж, батлагдсан график төлөвлөгөөний дагуу үүрэгжүүлж, ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Судалгаа хариуцсан орлогч дарга (С.Очир-Эрдэнэ), Ерөнхий инженер (Ж.Баясгалан), ажлын хэсгийн ахлагч (В.Мөнхжаргал, Э.Энхбаяр) нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүү менежмент хариуцсан орлогч дарга (Б.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГА



Ч.РЭГЗМАА